

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2011 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА	Д.БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б. ДААЖАМЦ
ХОРООНЫ ГИШҮҮН	П. ХЭРЛЭН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х.БУМ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА	С.ГАНБОЛД
ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА	П.ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ	Э.ЭРДЭНЭТУЯА
--------------------------------	--------------

УЛААНБААТАР ХОТ
2011.05.09

ГАРЧИГ

- I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- II. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- III. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- IV. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- V. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- VI. ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- VII. ДААТГАГЧ АШИГТ АЖИЛЛАГАА\
- VIII. ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- IX. ДАВХАР ДААТГАЛ
- X. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- XI. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ
- XII. ДҮГНЭЛТ
- XIII. ХАВСРАЛТ

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2011 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2011 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр 17 даатгалын компани, 1592 даатгалын төлөөлөгч, 9 даатгалын зуучлагч, 7 даатгалын хохирол үнэлэгч, 12 актуарч, нийт 1776 даатгалын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаа явуулсан дүнтэй байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид, тоогоор

№		2009 он	2010 он	2011 он
1	Даатгагч	16	17	17
2	Даатгалын компанийн салбар	120	131	139
3	Даатгалын төлөөлөгч	1 167	1 874	1592
4	Даатгалын зуучлагч	4	6	9
5	Даатгалын хохирол үнэлэгч		3	7
6	Актуарч	9	10	12
	А-АА	1 316	2 041	1776

Тайлант улиралд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан компани байхгүй мөн зохион байгуулалт, нэрийн өөрчлөлт хийгдээгүй.

График-1



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2009 оны 1 дүгээр улирлаас 2010 оны 1 дүгээр


улирал хүртэл 725-аар өссөн бол 2011 онд 265 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр буурсан байна. Энэ нь даатгалын төлөөлөгчдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 282 – оор буурсантай холбоотой. (График-1).

II. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2011 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 58,4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 17,7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хорооны 2009 оны 06 дугаар сарын 25 ны өдрийн 153 дугаар тогтоолоор 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс “Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөг” байхаар баталсан. Үүнтэй холбоотой даатгалын компаниудын нийт хөрөнгө огцом нэмэгдэж, 2011 оны 1 дүгээр улиралд 2007 оны мөн үеийнхээс 2,0 дахин өссөн байна.

2007 оны 1 дүгээр улиралд 28,4 тэрбум төгрөг байсан бол, 2008 оны 1 дүгээр улиралд 34,3 тэрбум төгрөг, 2009 оны 1 дүгээр улиралд 34,0 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үед 40,7 тэрбум төгрөг болон өсч, тайлант оны 1 дүгээр улиралд 58,4 төгрөгт хүрсэн байна. (График-2).

График-2



2011 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 16443.1 сая төгрөгийн хөрөнгөтэй буюу нийт зах зээлийн 28,1 хувийг эзэлж даатгалын салбарыг нийт хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаа бол “Жонон даатгал” ХХК 1378.3 сая төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт зах зээлийн 2,4 хувийг эзэлж байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ

/сая төгрөгөөр/

	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь

1	Ард даатгал ХХК	3,010.2	5.2
2	Бодь даатгал ХХК	5,693.7	9.7
3	Ган зам даатгал ХХК	1,827.3	3.1
4	Гранд даатгал ХХК	1,639.5	2.8
5	Жонон даатгал ХХК	1,378.3	2.4
6	МИГ даатгал ХХК	3,751.9	6.4
7	Монгол даатгал ХХК	16,443.1	28.1
8	Монгол траст холдинг даатгал ХХК	1,686.2	2.9
9	Моннис даатгал ХХК	1,414.8	2.4
10	Мөнх даатгал ХХК	1,491.3	2.6
11	Номин даатгал ХХК	3,076.4	5.3
12	Нэйшнл лайф даатгал ХХК	2,078.1	3.6
13	Практикал даатгал ХХК	4,176.4	7.1
14	Тэнгэр даатгал ХХК	4,540.7	7.8
15	Соёмбо даатгал ХХК	2,880.0	4.9
16	УБ даатгал ХХК	1,603.9	2.7
17	УБ хотын даатгал ХХК	1,734.7	3.0
	дүн	58,426.5	100.0

Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Хорооны 2008 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмаар дүрмийн болон нөөц сангийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хэлбэр, богино хугацаат хөрөнгө оруулалтын үзүүлэлтүүд өсөх хандлага ажиглагдаж байна.

2011 оны 1 дүгээр улиралд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ, богино хугацаат хөрөнгө оруулалт нийт 32765.7 сая төгрөг байгаа бөгөөд нийт эргэлтийн хөрөнгийн 66,92 хувийг эзэлж, Тайлант улиралд өмнөх оны мөн үеийнхээс 0,92 пунктээр өссөн байна. /Хүснэгт-3/

Үзүүлэлтүүд	/Хүснэгт-3/				/сая төгрөгөөр/	
	2009-01 улирал		2010-01 улирал		2011-01 улирал	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	21,675.90	71.56	23,496.00	66.00	32,765.70	66.92

Богино хугацаат хөрөнгө оруулалт	3,749.30	12.38	6,572.70	18.46	10,251.80	20.94
Дансны авлага	3,802.00	12.55	4,390.00	12.33	5,295.60	10.82
Бусад эргэлтийн хөрөнгө	1,062.20	3.51	1,140.00	3.20	648.60	1.32
Эргэлтийн хөрөнгийн дүн	30,289.40	100.00	35,598.70	100.00	48,961.70	100.00

Даатгагчдын нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа эргэлтийн хөрөнгийн бүтцийг сүүлийн 3 жилийн мөн үеийн байдлаар харахад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ хамгийн өндөр буюу дунджаар 68,16 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 17,26 хувь, дансны авлага дунджаар 11,9 хувь, бусад эргэлтийн хөрөнгө дунджаар 2,7 хувьтай байна.

Тайлант улиралд өмнөх оны мөн үеийнхээс эргэлтийн хөрөнгөнд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 0,92 пунктээр өсч, мөн богино хугацаат хөрөнгө оруулалт 2,48 пунктээр өсч, харин дансны авлага 1,51 пунктээр, 1,9 пунктээр тус тус буурсан байна. Үүнээс үзэхэд даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгийн үзүүлэлтүүдээс мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, хөрөнгө оруулалтууд ихээхэн хувийг эзэлсэн байна. Гэхдээ “богино хугацаат хөрөнгө оруулалт” гэдэг ойлголтонд 3 сараас дээш хугацаатай банкны хугацаат хадгаламжууд хамрагддаг учраас эргэлтийн хөрөнгийн ихэнх хэсгийг үндсэндээ мөнгөн хөрөнгө бүрдүүлж байгаа юм.


III. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 4 жилийн 1 дүгээр улирлын байдлаар дүгнэж үзэхэд 2008 оны 1 дүгээр улиралд даатгалын нөөц сан 63,0 хувь эзэлж байсан бол 2009 оны 1 дүгээр улиралд 43,0 хувь, 2010 оны 1 дүгээр улиралд 58,5 хувь, 2011 оны 49,5 хувь болон тус тус буурсан бөгөөд эзэмшигчийн өмч 2008 оны мөн үед 29,7 хувь байсан бол тайлант оны мөн үед 45,2 хувь болж 15,5 пунктээр өссөн байна.

Даатгалын нөөц сан 2008 оноос 2009 оны хооронд ихээхэн буурсан нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэх болсонтой холбоотой байсан байна. Харин 2009 оноос 2010 онд даатгалын нөөц сан өссөн нь “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-аар орлогод тооцоогүй хураамж нь балансын “нөөц сан” гэсэн үзүүлэлтэнд орохоор болсонтой холбоотой юм. (График-4).

График-4

Өр төлбөр, эзэмшигчдийн өмч, нөөц сангийн харьцаа



Хүснэгт-4

	2008-1 улирал	2009-1 улирал	2010-1 улирал	2011-1 улирал
Өр төлбөр	7.3	23.5	6.6	5.3
Нөөц сан	63	43	58.5	49.5
Эзэмшигчдийн өмч	29.7	33.5	31.0	45.2
Нийт хөрөнгө	100.0	100.0	96.1	100.0

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувь 2008 оны 1 дүгээр улиралд 29,7 хувь байсан бол 2011 оны 1 дүгээр улиралд 45,2 хувь болж өмнөх онуудын мөн үеийнхээс 15.5 пунктээр өссөн байна.

Мөн нөөц сан 2010 оны 1 дүгээр улиралд 58,5 хувь байсан бол тайлант оны мөн үед 49,5 хувь болж өмнөх оны мөн үеийнхээс 0,9 пунктээр буусан байна.

2010 оны 1 дүгээр улиралд өр төлбөр 6,6 хувийг эзэлж байсан бол 2011 оны 1 дүгээр улиралд 5,3 хувийг эзэлж өмнөх оны мөн үеийнхээс 1,3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

IV. ДААТГАГЧИЙН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагч болон урт хугацааны даатгалын компанийн нийт орлого 8946.9 сая төгрөг байна. Үүний ердийн даатгалын хураамжийн орлого 8903.7 сая төгрөг, урт хугацааны даатгалын компанийн орлого 43.2 сая төгрөг байна.

Тайлант улиралд ердийн даатгалын компанийн давхар даатгалын хураамж 2795.4 сая төгрөг, буцаасан даатгалын хураамж 19.8 төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 5442.3 сая төгрөгт хүрсэн байна. Урт хугацааны даатгалын компанийн хувьд давхар даатгалын хураамж 7,2 сая төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 36,0 сая төгрөг байна.

2011 оны 1 дүгээр улиралд даатгалын нийт хураамжийн орлогыг ердийн болон урт хугацааны даатгалын хэлбэрээр нарийвчлан харахад өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн даатгал 972,7 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 830,1 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 1351,9 сая төгрөгөөр, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 304,6 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 51,2 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 25,2 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 1,4 сая төгрөг, хуримтлалын даатгал 16,6 сая төгрөг, ачааны даатгал 86,9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, барилга угсралтын даатгал 51,9 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 20,8 сая төгрөгөөр, газар тариалангийн даатгал 0,3 сая төгрөг, мал амьтдын даатгал 2,1 сая төгрөгөөр тус тус буурч, нийт дүнгээр 3936,9 сая төгрөгөөр өмнөх оны мөн үеийнхээс өссөн үзүүлэлттэй байна. (Хүснэгт-5).

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2010.03.31	2011.03.31	Өөрчлөлт +/-, /- /
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	
1.2. Хөрөнгийн даатгал	1 180.4	2153.1	972.7
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	1 093.4	1923.5	830.1
1.8. Агаарын хөлгийн даатгал	650.5	1022.3	371.8
1.10. Хариуцлагын даатгал	633.9	1985.8	1351.9
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	542.9	847.5	304.6
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	329.9	381.1	51.2
1.11. Санхүүгийн даатгал	217.6	242.8	25.2
1.5. Барилга угсралтын даатгал	175.5	123.6	-51.9
1.4. Ачааны даатгал	137.1	224	86.9
2.1. Хугацаат амьдралын даатгал	18.9	18.5	-0.4
2.5. Эрүүл мэндийн даатгал	27.4	6.6	-20.8
1.7. Мал амьтдын даатгал	2.1		-2.1
1.6. Газар тариалангийн даатгал	0.3		-0.3
2.3. Хуримтлалын даатгал	0.1	16.7	16.6
2.4 Тэтгэврийн даатгал	0.0	1.4	1.4
ДҮН	5 010.0	8 946.9	3 936.9

Даатгалын компаниудыг 2011 оны 1 дүгээр улиралд олсон даатгалын хураамжийн орлогын хэмжээгээр жагсаахад нийт хураамжийн орлогын 22,8 хувь буюу 2038,9 сая төгрөгийг “Бодь даатгал” бүрдүүлсэн бол дараа нь 21,7 хувь буюу 1943,4 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК, салбарын гуравдугаарт нийт хураамжийн орлогын 11,4 хувь буюу 1021,7 сая төгрөг “Миг даатгал” ХХК-иуд тус тус эзэлж нийт хураамжийн орлогын 55,9 хувь буюу 5004,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна

Тайлант оны 1дүгээр улиралд нийт хураамжаар “Жонон даатгал ХХК 0,1 хувь, ”“Ганзам даатгал” ХХК 0,6 хувь, “Мөнх даатгал” ХХК 0,4 хувь, “Нэйшнл лайф даатгал” ХХК 0,5 хувь “УБ даатгал” ХХК 0,5 хувь эдгээр 5 компани ердөө нийт салбарын хэмжээний 2,1 хувийг эзэлсэн байгаа нь үйл ажиллагааны цар хэмжээ нь маш бага

байгаа харагдаж байна. “Монгол траст холдинг даатгал” орлого төвлөрүүлээгүй байна (Хүснэгт-6).

/сая төгрөгөөр/

	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	650.4	7.3
2	Бодь даатгал ХХК	2,038.9	22.8
3	Ган зам даатгал ХХК	52.5	0.6
4	Гранд даатгал ХХК	343.8	3.8
5	Жонон даатгал ХХК	10.2	0.1
6	МИГ даатгал ХХК	1,021.7	11.4
7	Монгол даатгал ХХК	1,943.4	21.7
8	Монгол траст холдинг даатгал ХХК	-	0.0
9	Моннис даатгал ХХК	589.8	6.6
10	Мөнх даатгал ХХК	31.9	0.4
11	Номин даатгал ХХК	314.5	3.5
12	Нэйшнл лайф даатгал ХХК	43.2	0.5
13	Практикал даатгал ХХК	228.6	2.6
14	Тэнгэр даатгал ХХК	834.6	9.3
15	Соёмбо даатгал ХХК	678.9	7.6
16	УБ даатгал ХХК	40.8	0.5
17	УБ хотын даатгал ХХК	123.6	1.4
	ДҮН	8,946.8	100.0

V. ДААТГАГЧИЙН НӨХӨН ТӨЛБӨР

2011 оны 1 дүгээр улиралд даатгалын компаниуд даатгуулагч иргэд, байгууллагуудад нийт 2049.0 сая төгрөгийн даатгаын нөхөн төлбөр олгосон ба үүнээс ердийн даатгагч 2039,4 сая төгрөг, урт хугацааны даатгагч 9,6 сая төгрөгийг нь олгосон байна.

(Хүснэгт-7).

Даатгалын хэлбэр	2010.03.31	2011.03.31	Өөрчлөлт
	Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)		
1.2. Хөрөнгийн даатгал	407	318.4	-88.60
1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал	719.7	951.8	232.10
1.8. Агаарын хөлгийн даатгал	1.7		-1.70
1.10. Хариуцлагын даатгал	55	135.6	80.60
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	153.4	208.1	54.70
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	202.2	269.8	67.60
1.11. Санхүүгийн даатгал	55.7	118.0	62.30
1.5. Барилга угсралтын даатгал	37.7		-37.70
1.4. Ачааны даатгал	9.5	31.9	22.40
2.1. Хугацаат амьдралын даатгал	1.0	4.3	3.30
2.5. Эрүүл мэндийн даатгал	0.5	3.2	2.70
1.7. Мал амьтдын даатгал		5.8	5.80

1.6. Газар тариалангийн даатгал			0.00
2.3. Хуримтлалын даатгал		2.1	2.10
ДҮН	1643.4	2 049.0	407.1

Тайлант оны 1 дүгээр улирлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал олгосон даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэр тус бүрээр харьцуулж үзвэл автотээврийн хэрэгслийн даатгал нийт нөхөн төлбөрийн 232,1 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 67,6 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 54,7 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 62,3 сая төгрөгөөр, ачааны даатгал 22,4 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 80.6 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 3.3 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 2.7 сая төгрөгөөр, мал амьтадын даатгал 5.8 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 2.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол хөрөнгийн даатгал 88,6 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 1.7 сая төгрөгөөр, барилга усралтын даатгал 37,7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт-8

	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	183.9	9.0
2	Бодь даатгал ХХК	166.9	8.1
3	Ган зам даатгал ХХК	8.5	0.4
4	Гранд даатгал ХХК	10.5	0.5
5	Жонон даатгал ХХК	41.6	2.0
6	МИГ даатгал ХХК	195.7	9.6
7	Монгол даатгал ХХК	821.4	40.1
8	Монгол траст холдинг даатгал ХХК	0.9	0.0
9	Моннис даатгал ХХК	-	0.0
10	Мөнх даатгал ХХК	29.5	1.4
11	Номин даатгал ХХК	144.6	7.1
12	Нэйшнл лайф даатгал ХХК	9.6	0.5
13	Практикал даатгал ХХК	64.4	3.1
14	Тэнгэр даатгал ХХК	230.0	11.2
15	Соёмбо даатгал ХХК	107.2	5.2
16	УБ даатгал ХХК	21.1	1.0
17	УБ хотын даатгал ХХК	13.2	0.6
	ДҮН	2,049.0	100.0

Даатгалын компаниудын нөхөн төлбөр олголтоор “Монгол даатгал” ХХК 821,4 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 40,1 хувийг эзэлж байгаа бөгөөд “Моннис даатгал” ХХК даатгалын нөхөн төлбөр олгоогүй байна.

2011 оны 1 дүгээр улиралд Даатгалын нөхөн төлбөр 2049, сая төгрөг байгаа бөгөөд “Ард даатгал” ХХК 183,9 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 9,0 хувь, “Бодь даатгал” ХХК 166,9 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 8,1 хувь, “Ганзам даатгал” ХХК 8,5 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 0,4 хувь, “Гранд даатгал” ХХК 10,5 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 0,5 хувь, “Жонон даатгал” ХХК 41,6 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 2,0 хувь, “Миг даатгал” ХХК 195,7 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 9,6 хувь, “Монгол траст холдинг даатгал” ХХК 195,7 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 9,6 хувь, “Мөнх даатгал” ХХК 29,5 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 1,4 хувь, “Номин даатгал” ХХК 144,6 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 7,1 хувь, “Практикал даатгал” ХХК 64,4 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 3,1 хувь, “Тэнгэр даатгал” ХХК 230,0 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 11,2 хувь “Соёмбо даатгал” ХХК 107,2 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 5,2 хувь

“УБ даатгал” ХХК 21,1 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 1,0 хувь “УБ хотын даатгал” ХХК 13,2 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 0,6 хувийг тус тус эзэлж байна.

VI. ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2009 оны 1 дүгээр улиралд даатгалын хохирол нөхөлтийн харьцаа 28.6 хувь, 2010 оны 1 дүгээр улиралд 33.1 хувь, 2011 оны 1 дүгээр улирал 33.1 хувь, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад өөрчлөлтгүй байна. (График-10).

График-10



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр 2010 оны мөн үеийн үзүүлэлтийг 2011 оны 1 дүгээр улиралд оны үзүүлэлттэй харьцуулахад даатгалын компаниуд дараах байдлаар харагдаж байна.

Хүснэгт-9

Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин		Өсөлт бууралт /пунктээр/
		2010-01	2011-01	
1	Ард даатгал ХХК	55.7	41.3	-14.42
2	Бодь даатгал ХХК	19.7	24.6	4.91
3	Ган зам даатгал ХХК	4.5	6.2	1.73
4	Гранд даатгал ХХК	0	6.2	6.23
5	Жонон даатгал ХХК	0	69.9	69.88
6	МИГ даатгал ХХК	45.8	31.5	-14.33

7	Монгол даатгал ХХК	48.9	44.7	-4.19
8	Монгол траст холдинг даатгал ХХК	0	74.0	74.03
9	Моннис даатгал ХХК			0.00
10	Мөнх даатгал ХХК	15.4	25.9	10.49
11	Номин даатгал ХХК	48.1	32.0	-16.15
12	Нэйшнл лайф даатгал ХХК	0	36.3	36.29
13	Практикал даатгал ХХК	29.4	11.2	-18.23
14	Тэнгэр даатгал ХХК	12.5	34.6	22.14
15	Соёмбо даатгал ХХК	63.7	34.5	-29.24
16	УБ даатгал ХХК	71.9	47.4	-24.54
17	УБ хотын даатгал ХХК	32.5	26.4	-6.10
	ДҮН	33.1	33.1	0.00

Даатгалын компаниудын 2011 оны 1 дүгээр улиралд олгосон хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Бодь даатгал” ХХК 4,91 пунктээр, “Ганзам даатгал” ХХК 1,73 пунктээр “Гранд даатгал” ХХК 6,23 пунктээр, “Жонон даатгал” “Мөнх даатгал” ХХК 10,49 пунктээр, “Нэйшнл лайф даатгал” ХХК 36,29 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 22,14 пунктээр тус тус өссөн бол “Ард даатгал” ХХК 14,42 пунктээр “Монгол даатгал” ХХК 4,19 пунктээр, “Миг даатгал” ХХК 14,33 пунктээр, “Номин даатгал” ХХК 16,15 пунктээр, “Практикал даатгал” ХХК 18,23 пунктээр, “Соёмбо даатгал” ХХК 29,54 пунктээр, “УБ даатгал” ХХК 24,54, “УБ хотын даатгал” ХХК 6,10 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

VII. АШИГТ АЖИЛЛАГАА

2011 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудыг тайлант үеийн цэвэр ашиг 1980,7 сая төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 561,8 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт зах зээлийн 28,4 хувийг эзэлж байгаа бөгөөд “Практикал даатгал” ХХК 346,1 сая төгрөг буюу 17,5 хувь, “Бодь даатгал” ХХК 253,7 сая төгрөг буюу 12,8 хувь, “Номин даатгал” ХХК 188,7 сая төгрөг буюу 9,5 хувь Тэнгэр даатгал” ХХК 159,2 сая төгрөг буюу 8,0 хувь “Ганзам даатгал” ХХК 116,0 сая төгрөг буюу 5,9 хувийг тус тус эзэлж эдгээр компаниуд нийт зах зээлийн 82,1 хувийг эзэлсэн байна. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд ашигтай ажилласан байна. 2011 оны 1 дүгээр улиралд “Нэйшнл лайф даатгал” ХХК 65,2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба нийт салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлж байна. (Хүснэгт-10).


Хүснэгт-10

Даатгалын компанийн 2011 оны 1 дүгээр улирлын цэвэр ашиг (алдагдал)

	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	90.2	4.6
2	Бодь даатгал ХХК	253.7	12.8
3	Ган зам даатгал ХХК	116.0	5.9
4	Гранд даатгал ХХК	46.6	2.4
5	Жонон даатгал ХХК	16.1	0.8
6	МИГ даатгал ХХК	38.0	1.9
7	Монгол даатгал ХХК	561.8	28.4
8	Монгол траст холдинг даатгал ХХК	12.7	0.6
9	Моннис даатгал ХХК	45.9	2.3
10	Мөнх даатгал ХХК	1.7	0.1
11	Номин даатгал ХХК	188.7	9.5
12	Нэйшнл лайф даатгал ХХК	(65.2)	-3.3
13	Практикал даатгал ХХК	346.1	17.5
14	Тэнгэр даатгал ХХК	159.2	8.0
15	Соёмбо даатгал ХХК	97.6	4.9
16	УБ даатгал ХХК	41.5	2.1
17	УБ хотын даатгал ХХК	30.1	1.5
	ДҮН	1,980.7	100.0

VIII. ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 4 жилийн мөн үеийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд 2009 оны 1 дүгээр улиралд буурч 2010 оноос хойш өсч улмаар 2011 оны мөн үед 28,8 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Тайлант улирлын ердийн даатгалын компанийн нөөц сангийн үлдэгдэл 28,8 тэрбум төгрөг байгаа бөгөөд урт хугацааны даатгалын 109,7 сая төгрөгийн нөөц сангийн үлдэгдэлтэй байна. Хавсралт№ 01, Хавсралт№02

IX. ДАВХАР ДААТГАЛ

2009 оны 1 дүгээр улиралд давхар даатгалын хураамж 800.3 сая төгрөг, 2010 оны 1 дүгээр улиралд 1124.1 сая төгрөг, тайлант оны 1 дүгээр улиралд 2795.4 сая төгрөг болж тогтвортой өссөн байна. Өмнөх оны мөн үеийнхээс 1671,3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь “Моннис даатгал” ХХК, “Ганзам даатгал” ХХК, “УБ хотын даатгал” ХХК-иуд давхар даатгалын хураамж төвлөрүүлсэнтэй холбоотой юм.



2011 оны 1 дүгээр улиралд төлсөн давхар даатгалд “Ард даатгал” ХХК 38,4 сая төгрөг, “Бодь даатгал” ХХК 1409,9 сая төгрөг “Гранд даатгал” ХХК 151,8 сая төгрөг, “МИГ даатгал” ХХК 383,3 сая төгрөг “Монгол даатгал” ХХК 108,7 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 5,7 сая, төгрөг, “Тэнгэр даатгал” ХХК 104,5 сая төгрөг “Нэйшнл лайф даатгал” ХХК 7,2 сая “УБ хотын даатгал” ХХК 27,0 сая төгрөг, “Ганзам даатгал” ххк 21,5 сая төгрөг, “Моннис даатгал” ХХК 537,3 сая төгрөгийг тус тус давхар даатгалд төлсөн байна

X. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

Даатгалын зуучлагч компаниуд

Тайлант оны 1 дүгээр улиралд 9 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд “Скай-эрдэнэ” ХХК, “Жомолхари” ХХК, “Эм жи ай би” ХХК-иуд даатгалын зуучлалын орлогыг төвлөрүүлж ажиллаагүй байна.

Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 64,1 сая төгрөг болсон бөгөөд үүнээс даатгалын зуучлалын орлого 47,6 сая төгрөг, бусад орлого 16,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

№	Даатгалын зуучлагч компанийн нэр	Даатгалын зуучлалын орлого	Эзлэх хувь хэмжээ
1	“Асимон брокерс” ХХК	5.9	12.42
2	“АМЕ” ХХК	6.9	14.53
3	“Ачит ундарга” ХХК	8.4	17.68
4	“Лоялти солюшн” ХХК	4.0	8.42
5	“Эм Жи Ай Би” ХХК	0	
6	“Скай-Эрдэнэ” ХХК	0	
7	“Ренессанс групп” ХХК	8.8	18.53
8	“Жомолхари” ХХК	0	
9	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	13.5	28.42
	Нийт дүн	47.5	100.00

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Ренессанс групп” ХХК-иуд нийт даатгалын зуучлалын орлогын 46.7 хувийг эзэлсэн байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниуд

Тайлант улиралд нийт үндсэн үйл ажиллагааны орлого 43,8 сая төгрөг, үүнээс даатгалын хохирол үнэлгээний орлого 12,2 сая төгрөг, бусад орлого 35,2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-12

№	Даатгалын хохирол үнэлэгч компанийн нэр	Даатгалын хохирол үнэлгээний орлого	Эзлэх хувь хэмжээ
1	“Бест эстимэйт” ХХК	1.6	13.16
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	2.2	4.63
3	“Файн эстимэйт” ХХК	0	-
4	“Итгэлт эстимэйт” ХХК	3.8	8.00
5	“Мега марз” ХХК	0.9	1.89
6	“Вендо” ХХК	3.6	7.58
7	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0.06	0.13
	Нийт дүн	12.2	100.00

“Итгэлт эстимэйт” ХХК, “Вендо” ХХК-иуд нийлээд нийт даатгалын хохирол үнэлгээний орлогын 60,5 хувийг эзэлж байна. “Итгэлт эстимэйт” ХХК нь бусад орлого 25,5 сая төгрөг нийт 29,3 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлсэн бөгөөд нийт орлогын 66,8 хувийг дангаараа эзэлж байна.

ХИ. ДҮГНЭЛТ

Даатгалын зах зээл дээр 2011 оны 1 дүгээр улиралд үйл ажиллагаа явуулсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид нийт 9054,7 сая төгрөгийн орлого олсон байна. Энэхүү орлогын 8903,6 сая төгрөг буюу 98,3 хувийг ердийн даатгалын компаниуд, 43,2 сая төгрөг буюу 0,5 хувийг урт хугацааны даатгалын компани, 64,1 сая төгрөг буюу 0,7 хувийг даатгалын зуучлагч компаниуд, 43,8 сая төгрөг буюу 0,5 хувийг даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого тус тус бүрдүүлсэн байна.

Даатгагчийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 17,7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, тайлант үеийн цэвэр ашиг 1,9 тэрбум төгрөгт хүрсэн ба ердийн даатгагчид салбарын хэмжээнд ашигтай ажиллаж байгаа нь аливаа эрсдлийг даван туулах хандлага, чадвар нэмэгдэж байна гэж дүгнэхээр байна.

Даатгалын компаниуд өөрсдийн хүлээж буй болзошгүй даатгалын томоохон эрсдлийг давхар даатгагчид шилжүүлсэн байдал өмнөх оны мөн үеийнхээс 2.5 дахин өссөн байгаа нь давхар даатгалд даатгуулах даатгалын ач холбогдлыг илүү сайн мэдэрч байгаатай холбоотой юм.

Даатгалын салбарын 2011 оны 1 дүгээр улиралд нэгдсэн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулж үзэхэд даатгалын зах зээлийн тэлэлт явагдаж байгааг харж болохоор байна.

ДААТГАЛЫН ГАЗАР